15. Төвөгдөх шаардлага, шалтгаан, шалтгаан, шалтгаан

- Усны тусгай хуулийн 28.6-д заасны дагуу Хараа-Ерөө голын сав газрын зохиогчид ус ашиглах зөвшөөрөл авч, зохиогчийн дагуу гарах байгуулах;
- Усны тусгай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус төлөх шугам хоолой бүрт баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын замтаар усны нөөц шингэлсэн төлбөрийг тооцож, Төсвийн тусгай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлж;
- Усны тусгай хуулийн 28.16-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг зориглодог болохыг ажлаар;
- Хавтрал усны дүгнэлтийг дарма ажлын хэргийн үйлчилгээнд багтааж гаргуулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргах байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дугаар тогтоолоор баталсан агуу зөвшөөрсөн хэмжээгээс илүү ашигласан усны нөөц шингэлсэн төлбөрийг шалтгаангүйгээр тооцож ажлаар;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын зохиогч болон холбогдох төрийн зохиогчийн байгууллагуудад дөрүй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгах яриулах;
- Усны тусгай хуулийн 7.5-д заасны дагуу усны үнэ, усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (Газрын доорх усны хангалт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гарах, гарах дүгнэлт, усны нөөц шингэлсэн төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 30-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хэлтээр болон холбогдох гэрээнд хүргүүлж ажлаар;



Байгууллагын нэр: Усны газар
 Газар хэлтэс: Усны газар
 Албан тушаал: Даргын албыг түр орлон гүйцэтгэгч
 Овог нэр: Эннэмдар Батбаяр
 Зурсан огноо: 2024.05.15 14:05:45

Боловсруулсан:

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС: В.Энхсүрэн
 Боловсруулсан огноо: 2024.05.15

Хавсралт 2. Хараа-Ерөө голын сав газрын ус ашиглах гэрээ



**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУТЧЛАЛЫН ЯАМ
ХАРАА - ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА**

45053 Дархан-Уул аймаг, Дархан сум,
14-р баг Монгол банкны 3-р давхарт
Утас/Факс: 7037-3171, E-mail: kharaaeruu@yahoo.com

2024.05.28 № 62

танай _____-ны № _____-т

"ХАНДГАЙТ ГОЛ" ХХК-нд

Ус ашиглах гэрээ,
зөвшөөрөл хүргүүлэх тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.4 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-400/226 тоот хамтарсан тушаалаар баталсан Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", лабораторийн шинжилгээний дүн болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас ирүүлсэн 2024 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн Е-2404-000023 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, танай компанийн 2024 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 24/25 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ус ашиглах гэрээ байгуулан, зөвшөөрлийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ...хуудастай.

ДАРГА



Ө.АРИУНБААТАР



ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/23

Дархан

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн Е-2404-000023 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөө голын сав газарт Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт орших "Баянголын эх хөндий" нэртэй газрын 543.33 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-021595 дугаартай, 1311003083 улсын бүртгэлийн дугаартай, 2059681 тоот регистрийн дугаартай төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлон хуурай соронзон аргаар нунтаглан баяжуулах "Хандгайт гол" ХХК-нд 2024 онд Ерөө голын сав газрын газрын доорх усны нөөцөөс унд, ахуйд 21,789.0 м³/жил, шүүрэн орж ирэх 528,066,0 м³/жил, нийт 549,855 м³/жил ус авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д тус тус заасны дагуу ус ашиглах гэрээ байгуулан, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 28 дугаар зүйлийн 28.7, 28.18, 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт болон ус ашиглахад тавигдах шаардлага, эрх үүргийг мөрдөж ажиллах, Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдуулж ус ашиглалтын тайланг 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа технологийн усанд хийлгэсэн шинжилгээний дүгнэлт ус ашигласны төлбөрийн мэдээллийг улирал бүр Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд ирүүлэхийг "Хандгайт гол" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Н.Эрдэмбаяр)-т даалгасугай.

3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөө сумын засаг дарга Б.Сэргэлэн, Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга З.Түвшинтөгс нарт зөвлөсүгэй.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА
Ө.АРИУНБААТАР

My doc. A/Tushaal



2024 оны 05 сарын 28-ний өдөр



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 05

Дархан-Уул аймаг

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29-р зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн E-2404-000023 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2024 оны 05 сарын 28-ний өдрийн А-23 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын Захиргааны ахлах мэргэжилтэн Галя овогтой Оюунгэрэл, ус ашиглагчийг төлөөлж Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт орших Баянголын эх хөндий нэртэй газрын 543.33 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-021595 дугаартай тусгай зөвшөөрөлтэй, 1311003083 улсын бүртгэлийн дугаартай, 2059681 тоот регистрийн дугаартай төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлон хуурай соронзон аргаар нунтаглан баяжуулах "Хандгайт гол" ХХК-ний ерөнхий инженер Г.Нэмэхбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 05 сарын 28-ний өдрөөс 2024 оны 12 сарын 30-ний өдөр хүртэл 7 /долоо/ сарын хугацаатайгаар байгуулав.

1.2. Гэрээг монгол хэлээр 3% үйлдэж талуудад нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Хүн ам, үйлдвэрийн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

Уурхайн олборлолтын тоног төхөөрөмж:

HYUNDAI 520 LC9 маркийн эксковатор 1 ш	HOWO N3847B маркийн автосамосвал 8 ш
KOMAT'SU PC1250 маркийн эксковатор 1 ш	KOMAT'SU HD465 маркийн автосамосвал 4 ш
CATERPILLAR D6R маркийн бульдозер 1 ш	HOWO ZZ3257N-44147A маркийн автосамосвал 7 ш
SHANTUI SD23 маркийн бульдозер 1 ш	XCMG брендийн автогрейдер 1 ш
XCMG ZL50 GN маркийн утгуурт ачигч 2 ш	Усны машин 1 ш
XCMG 855N маркийн утгуурт ачигч 1 ш	

* Эдгээр машин техникүүд бүгд түрээсийнх

Баяжуулах боловсруулах үйлдвэрт ажиллуулах тоног төхөөрөмж:

GF4016 маркийн эксковатор 1 ш	910mm*10m-ын туузан конвейер 1 ш
J40 хацарт бутлуур 1 ш	1070mm*25m-ын туузан конвейер 1 ш
C35 маркийн конусан бутлуур 1 ш	1070mm*14m-ын туузан конвейер 1 ш
ЗҮК2460 чичиргээт шигшүүр 1 ш	1070mm*28m-ын туузан конвейер 1 ш
DFA25, 36*96 маркийн хуурай хүчтэй соронзон сепаратор 1 ш	1070mm*13m-ын туузан конвейер 1 ш
DFA50, 36*120 маркийн хуурай хүчтэй соронзон сепаратор 1 ш	910mm*17m-ын туузан конвейер 1 ш
910mm*33m-ын туузан конвейер 1 ш	910mm*14m-ын туузан конвейер 2 ш
760mm*20m-ын туузан конвейер 1 ш	910mm*30m-ын туузан конвейер 1 ш
910mm*11m-ын туузан конвейер 1 ш	760mm*14m-ын туузан конвейер 1 ш
	760mm*11m-ын туузан конвейер 1 ш
	910mm*20m-ын туузан конвейер 1 ш

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 549*855 м³/жил

Үүнээс: унд ахуйд 538 хүн x 150 л/хон x 270хон = 21,789.0 м³/жил

Үйлдвэрлэх боловсруулах бүтээгдэхүүнд зарцуулах хэмжээг холбогдох хууль, журам, норм стандартын дагуу тооцоход

$776 \text{ т.м} \times 10 \text{ м}^3 = 7760 \text{ м}^3/\text{жил}$ – Уурхайн өрөмдлөгт ашиглах ус,

$110'000 \text{ м}^2 \times 2.0 \text{ л/м}^2 \times 210 \text{ хон} = 46'200 \text{ м}^3/\text{жил}$ - Зам усалгаанд ашиглах ус,

$7760 \text{ м}^3/\text{жил} + 46'200 \text{ м}^3/\text{жил} = 53,960.0 \text{ м}^3/\text{жил}$ - Технологид ашиглах нийт усны хэмжээ

$1'955.8 \text{ м}^3/\text{хон} \times 270 \text{ хон} = 528'066.0 \text{ м}^3/\text{жил}$ - Шүүрэн орж ирэх усны хэмжээ БОННҮТ 10х

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйн болон үйлдвэрийн технологийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэрийн байршил: Усны газрын 2021.09.03-ны өдрийн "Эм И Си Эс Зэт Би" ХХК-д гаргаж хүргүүлсэн "Хандгайт гол" ХХК-ний "Баянголын эх хөндий" нэртэй MV-021595 дугаартай тусгай зөвшөөрөлтэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар олборлох төслийн унд ахуйн $40.5 \text{ м}^3/\text{хон}$ усыг өөрийн эзэмшлийн 2.51 л/сек буюу $216.86 \text{ м}^3/\text{хон}$ ундрагатай худгаас, зам талбайн тоосжилт дарах, өрөмдлөгийн ажил, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах $541.1 \text{ м}^3/\text{хон}$ усыг шүүрлийн уснаас авч ашиглахад ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

2.5 Усны барилга байгууламж: Баянголын эх хөндийн төмрийн ордыг ил аргаар ашиглах төслийн хаягдлын сангийн зураг төсөл байхгүй. Уурхайн ашиглалтын эхний жилд уурхайн ухлагаас шүүрлийн ус илэрхээргүй байна. Тунгаах сангийн эзэлхүүн 20.250 м^3 цэвэр усны сангийн эзэлхүүн 9.750 м^3 байна.

2.6. Дамжуулах байгууламж: Уурхайн ухлагаас усан сан хүртэл усыг дамжуулах ган хоолойн урт 75 м , голч 200 мм .

2.7. Хаягдал усны хэмжээ цэвэрлэгээний арга: Ахуйн хаягдал бохир усыг бага оврын Топ-аэро 32 маркийн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлнэ.

2.8. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд "Эм И Си Эс Зэт Би" ХХК хийж гүйцэтгэсэн

2.9. Худаг өргөлтийн станцууд, Усны тоолуур насосны хүчин чадал: Унд ахуйн худаг $106'58 \cdot 43,7 \cdot 49'38 \cdot 38,00 \cdot$ Ундарга-0.5 л/сек насос QG10052 Тоолуур Гран система.

2.10. Онцгой нөхцөл:

- Шар усны болон гэнэтийн үерийн ус уурхайн ухлага буюу ашиглалт явуулж буй талбай болон хаягдлын санд орохоос сэргийлэн зохих арга хэмжээ авах;

- Мэргэжлийн байгууллагаар шүүрлийн усны тооцоог ашиглалтын жилүүдээр хийлгэх;

- Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, зураг төсөлд усны газраар 2024 онд багтаан дүгнэлт гаргуулах.

- Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны өдрийн дотор Хараа-Ерөө голын сав газарт ирүүлэх;

- Усны тухай хуулийн 30.1.3-д заасны дагуу Хаягдал усны дүгнэлт гаргуулж үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдал усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж зайлуулах, усны нөөц горим, чанарын мэдээ болон ус ашиглалтын тайланг сав газрын захиргаанд ирүүлэх;

2.11. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" монгол улсын хуулийн 20.1.1-д заасны дагуу унд ахуйн усыг $21'789.0 \text{ м}^3/\text{жил}$ төлбөрөөс чөлөөлнө.

Уурхайн ухлагад шүүрэн орж ирж зайлуулах $528'066 \text{ м}^3/\text{жил}$ газрын доорхи усны төлбөрийн хэмжээг "Усны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах" тухай засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Ерөө голын сав газарт тогтоосон экологи-эдийн засгийн суурь үнэлгээ "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах" тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, 326 дугаар тогтоолд заасан төлбөрийн хувь хэмжээг ашиглан тооцож:

Шавхан зайлуулах 1 м^3 усны төлбөр

1 м^3 газрын доорх ус ашигласан төлбөр: $2764.0 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 1.4 = 580.44 \text{ төг/м}^3$

-2'764.0 төг/м³ –Хараа Ерөө голын сав газарт газрын ус ашигласан нөхцөлд экологи-
эдийн засгийн суурь үнэлгээ
-15%-Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц
ашигласны төлбөрийн 7в-д заасан хувь хэмжээ
-1.4 ашигт малтмал олборлон баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласан
нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

Нийт: 528'066.0 м³ x 580.44 төг/м³ = 306'510'629.04 төг

**/ Гурван зуун зургаан сая таван зуун арван мянга зургаан зуун хорин есөн төгрөг,
дөрвөн мөнгө /**

Төлбөр төлөлт: Усны нөөц ашигласны төлбөрийг Сэлэнгэ төрийн сан банкны 100130000944
тоот дансанд 2024 оны 08 сарын 01-ний дотор нийт төлбөрийн 50 хувийг, 2024 оны 10 сарын
31-ний дотор үлдсэн төлбөрийг хийж барагдуулсан байна.

Ус ашиглалтын мэдээ тайлан, болон усны нөөц ашигласны төлбөрийн үнийг орон нутгийн
төсөвт төлсөн хагас, бүтэн жилээр төвлөрүүлж Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд гаргаж
өгнө.

Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг Засгийн газрын 2018 оны 391 дүгээр
тогтоолоор батлагдсан журмын дагуу төлбөрийг шатлан өсгөхийг анхаарч ус ашиглалтын
календарьчилсан төлөвлөгөө графикийг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.


Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 17-р зүйл, 26, 27, 28, 29 30, 31-р зүйлд
заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад


- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг, дарж баталгаажсан өдрөөс эхлэн хүчин
төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус
зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг талууд 2024 оны 12 сарын 01-ний дотор ус ашиглалтын тайлан болон
усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл
үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр
хугацаанаас нь өмнө цуцална.
- 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
- 4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс
зөвшөөрөөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Ус ашиглуулагчийг төлөөлж:
ХЕГСГЗ-ны Уул уурхай, эрчим хүчний
ус ашиглалт зориулсан ахлах мэргэжилтэн
 Г.Оюунгарал

ХАЯГ:

Дархан-Уул аймаг, Дархан сумын 14 баг
Монгол банкны 3 давхарт Хараа-Ерөө
голын сав газрын захиргаа Утас: 70373171

Ус ашиглагчийг төлөөлж:
"Хандгайт гол" ХХК-ний ерөнхий инженер
 Г.Нэмэхбаяр

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8-р
Хороо Бага тойрог Сүбаатарын
талбай Сити Төвэр 13 давхар
Утас: 88880748, 99780728

Хавсралт 4. Худгийн өрөмдлөгийн гэрээ

БАТЛАВ:
“ХАНДГАЙТГОЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Х.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ:
“СОЙЛ ИНЖИНИРИНГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
А.БАТСАЙХАН

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 5-р сарын 29-ны өдөр № Улаанбаатар хот

Нэг талаас: “Хандгайтгол” ХХК /цаашид “Захиалагч” гэх/ түүнийг төлөөлж Х.Лхагвасүрэн
Нөгөө талаас: “Сойл Инжинеринг” ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж
Гүйцэтгэх захирал Ч.Нямдорж нар Монгол улсын Иргэний хуулийн 343-358-р зүйлийг үндэслэн дараах
нөхцөл бүхий гэрээг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний Хавсралт 1 -т тохиролцсон Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт малчдад зориулсан гүний 2 худгийг өрөмдлөгийн ажил /100 тууш метр/ /цаашид “Гэрээт ажил” гэх/-ыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, Захиалагчийн шаардлагад нийцүүлэн, чанарын өндөр түвшинд гүйцэтгэн Захиалагчийн өмчлөлд хүлээлгэж өгөх, Захиалагч нь Гүйцэтгэгчийн доголдолгүй гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч энэхүү гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлон зохицуулахад оршино.
- 1.2 Гүйцэтгэгч нь инженер-геологийн судалгааны ажлын хүрээнд Захиалагчийн даалгавраар заасан талбайд өрөмдлөг хийж тоноглол, цооногт шүүрэлт тодорхойлох, өрөмдлөгийн ажлын тайлан бичиж баримтжуулахад хийнэ.
- 1.3 Энэхүү гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль түүнд нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁР. Гэрээний зүйл

- 2.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь гэрээний 1.1 дэх хэсэгт тодорхойлсон барилгажих талбайд Хавсралт №1-г заасан өрөмдлөг тоноглол, цооногт шүүрэлт тодорхойлох ажлыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, Захиалагчийн шаардлагад нийцүүлэн, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэж өгнө.

2.2 ГУРАВ. Гэрээний хугацаа

- 3.1 Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг 2024 оны 06-р сарын 03-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд гүйцэтгэж Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
- 3.2 Захиалагчтай холбоотой бусад шалтгаанаар хойшлогдсон хугацааг энэ гэрээний 3.1-р зүйлд заасан ерөнхий хугацаан дээр нэмж тооцно.

ДӨРӨВ. Гэрээний үнэ, төлбөр төлөх журам

- 4.1 Гэрээний нийт үнийн дүн нь /НӨАТ/ орсон дүнгээр 26,499,000.00 /Хорин дөрвөн сая дөрвөн зуун ерэн есон мянга / төгрөг болно.
- 4.2 Энэхүү гэрээний нийт үнийн дүнд Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 100 тууш метр өрөмдлөгийн үнэ, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний цалин хөлс, томилот, компанийн ашиг, аливаа татвар хураамж зэрэг бүхий л зардлууд орсон болно.
- 4.3 Захиалагч нь гэрээний төлбөрийг дараах журмаар төлнө. Үүнд:
 - 4.3.1 Гэрээ байгуулагдаж хүчин төгөлдөр болсоноор нийт үнийн дүнгийн 30%-тай тэнцэх төлбөр буюу 8,000,000.00 төгрөгийг
 - 4.3.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөр үлдэгдэл 30%-тай тэнцэх төлбөр буюу 8,000,000.00 төгрөгийг
 - 4.3.3 Захиалагч 2024 оны 10-р сарын 15-ны дотор 40% буюу 10,499,000.00 төгрөгийг Гүйцэтгэгчийн харилцах дансанд шилжүүлнэ.

**ТАВ. Гүйцэтгэх ажлын үр дүн, тавигдах шаардлага,
хүлээлгэн өгөх журам**

- 5.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох стандарт, Захиалагчийн хүсэл сонирхол, тавьсан шаардлагын дагуу мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 5.2 Гүйцэтгэгчийн энэхүү гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг Захиалагч шалгах бөгөөд ажлын үр дүн холбогдох стандарт, Захиалагчаас тавьсан шаардлагад нийцсэн гэж үзвэл ажлын үр дүнг баталгаажуулан актаар хүлээн авна.
- 5.3 Хэрэв гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэсэн, эсвэл зураг төсөл, өгсөн даалгавраас зөрүүтэй гүйцэтгэсэн нь шалгах явцад илэрсэн бол Гүйцэтгэгч доголдлыг Захиалагчаас тогтоосон хугацаанд үнэ төлбөргүй арилгах ба ийнхүү арилгах хүртэл Захиалагч гэрээт ажлын үр дүнг хүлээн авахгүй.
- 5.4 Өрөмдлөгийн ажлын тайлан дүгнэлтийг Монгол, Англи хэл дээр хоёр хувь хийж, Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. Захиалагчийн эрх, үүрэг

- 6.1 Өрөмдлөг явуулах объектын тогтоосон масштабтай дэвсгэр болон байрзүйн зургийг гаргаж өгөх буюу байршлыг газар дээр нь зааж өгнө.
- 6.2 Судалгааны талбайд шахилгаан, холбоо, цэвэр ба бохир усны инженерийн байгууламжийн шугамыг оруулахгүй байлгах нөхцлийг хангасан байна. Үүнээс үүссэн аливаа асуудлыг өөрөө хариуцна.
- 6.3 Гүйцэтгэгчийн гэрээт ажлын гүйцэтгэлд байнга хяналт тавьж, мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 6.4 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг Захиалагчийн эрх бүхий төлөөлөгч нарийн шалгаж актаар хүлээн авах бөгөөд ийнхүү шалгах явцад ажлын үр дүн, тайланд аливаа доголдол илэрсэн, өгсөн зөвлөмжийг дагаагүй нь тогтоогдвол Гүйцэтгэгч доголдлыг шаардлагад нийцүүлэн арилгах хүртэл Захиалагч хүлээн авахаас татгалзах ба Гүйцэтгэгчээр доголдлыг үнэ төлбөргүй арилгуулах, гуравдагч этгээдээр доголдлыг арилгуулсан тохиолдолд холбогдон гарсан зардлыг төлүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд Гүйцэтгэгчийн доголдол арилгасан хугацааг гэрээний хугацааг хэтэрсэнд тоошно.
- 6.5 Гүйцэтгэгчээс хүлээлгэн өгч байгаа гэрээт ажлын үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй.
- 6.6 Гэрээний төлбөрийг гэрээгээр тохирсон журмын дагуу хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- 6.7 Аливаа газрын маргаантай асуудал тулгарвал нэн даруй шийдвэрлэх ба өрөмдлөг явуулах хэвийн нөхцөлийг хангах, эс чадвал сул зогсолтыг хойшлогдсон хоног тутам төлөх үүрэгтэй.
- 6.8 Цооногт шүүрэлт тодорхойлоход ашиглах усан хангамжийг өрөмдлөгийн талбайд бэлэн байлгах

ДОЛОО. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 7.1 Захиалагчийн заасан газарт энэхүү гэрээний 2.1 дэх хэсэгт өрөмдлөг хийж тоноглон, шүүрэлт тодорхойлох, тайлан, зураг зүсэлт боловсруулах ажлуудыг мэргэжлийн түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 7.2 Захиалагчаас гэрээгээр тохиролцсон төлбөрийг хугацаанд нь хийхийг шаардах эрхтэй.
- 7.3 Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам зааврыг чанд мөрдөж ажиллах бөгөөд үйддвэрлэлийн осол гаргахгүй байхаас гадна гуравдагч этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлж ажиллана. Үүнтэй холбогдуулан үүссэн аливаа хохирлыг өөрөө хариуцна. Ажлын талбайд ажиллах ажилчдаа хөдөлмөрийн сахилга баттай, нарийн зохион байгуулалттай ажиллуулж, аливаа зөрчил дутагдал гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах ба зөрчил дутагдал гаргасан бол үүссэн хохирлыг Гүйцэтгэгч өөрөө бүрэн хариуцна.
- 7.4 Гүйцэтгэгчийн ажилчид гэрээт ажлыг гүйцэтгэх явцад, гэрээ дуусгавар болсоны дараа Захиалагчийн талаарх аливаа мэдээллийг нууцлан хадгалах ба бусдад мэдээлэхгүй. Энэ үүргээ зөрчсөнтэй холбогдон үүссэн хохирлыг Захиалагчид бүрэн нөхөн төлнө.
- 7.5 Захиалагчаас Гүйцэтгэгчид шилжүүлсэн баримт бичиг, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд ажил гүйцэтгэж дууссаны дараа Захиалагчид эргүүлэн шилжүүлэх үүрэгтэй.
- 7.6 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Захиалагчийн хөдөлмөрийн дотоод дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

7.7 Захиалагчийн аливаа гуравдагч этгээдийн нэхэмжлэл, маргаан, төлбөр зэргээс ангид байлгах үүрэгтэй.

НАЙМ. Хариуцлага

- 8.1 Гүйцэтгэгч гэрээт ажлыг хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 8.2 Захиалагч нь гэрээний үнийг харилцан тохиролцсон журмын дагуу шилжүүлээгүй тохиолдолд төлбөрийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0,5%-тай тэнцэх алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

ЕС. Гэрээ цуцлах

- 9.1 Гэрээг дараахь тохиолдолд Захиалагч дангаар цуцална.
- 9.1.1 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлаа хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй 15 (арван тав) хоног өнгөрсөн.
- 9.1.2 Гүйцэтгэгч нь дампуурсан эсвэл бусдад эрхээ шилжүүлсэн.
- 9.1.3 Гүйцэтгэгч нь хариуцсан ажлаа удаа дараалан (2 ба түүнээс дээш) чанаргүй гүйцэтгэсэн.
- 9.1.4 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу үүрэг хүлээх чадваргүй нь нэгэнт тогтоогдсон.
- 9.2 Торгууль алданги төлсөн нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхээс чөлөөлөхгүй.
- 9.3 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй 15 ба түүнээс дээш хоног хэтэрвэл Гүйцэтгэгч өөрийн санаачлагаар гэрээг цуцална. Үүнээс үүссэн бодит хохирлыг Захиалагч тал хугацаа хэтэрсэн хоног тутамд тооцсон алдангийн хамт төлнө.

АРАВ. Бусад нөхцөл

- 10.1 Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгийн хэлбэрээр үйлдэгдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2 Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэнэ. Маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 10.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдвол талууд энэ талаар бичгээр нөгөө талдаа ажлын нэг хоногийн дотор мэдэгдэж зөвшилцөж шийдвэрлэнэ. Давагдашгүй хүчин зүйл учирсныг зөвхөн эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэж тогтооно.
- 10.4 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэн, талууд тус бүр хоёр хувийг хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Нэмээбаяр, Уурхайн срөнхий инженер
Утас: 88073097

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Ч.Нямдорж, Гүйцэтгэх захирал
Утас: 88107265

малчны худаг болон ордон гидрогеологийн судалгааны гэрээний үнийн дүн болон төлбөрийн хувиарь

№	хийгдэх ажлууд	талбайн байршил	ажлын тоо	ажлын хэмжээ Т.м	үнийн дүн, төлбөрийн хувиар				тайлбар
					Урьдчилгаа	явцын төлбөр	үлдэгдэл төлбөр	нийт төлбөр	
1	Малчны гүний худаг	Ерөө сум, сумын засаг даргаас өгсөн 2 цэгт	2 ширхэг	100	8,000,000.00	8,000,000.00	10,499,000.00	26,499,000.00	насос, кабель, тросс төлбөр нэмэгдэх
2	Ордон гидрогеологийн судалгаа	Ерөө сум, Хандгайт гол уурхай	2 ширхэг	300	8,370,000.00		75,337,030.00	83,707,030.00	шавхалт туршилт, хяналтын цооногын зориулалтаар тоноглох, тайлан, дүгнэлт, жил бүрээр шүүрлийн усны тооцоо

Малчны худаг гаргах цэгийн координат

№	East (X)	North (Y)
Худаг-1	640684.587	5497911.754
Худаг-2	639183.429	5497048.564

Өрөмдлөг, худаг ус, судалгааны
СОЙЛ ИНЖИНЕРИНГ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, М Плаза Центр, 10-р давхар
 Утас: 70135666, Факс: 976-11-70135666. Мобил: 9911-5666, 9907-7661

2024 оны 04-р сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ МАЛЧДЫГ ХУДГИЙН ҮНЭЛГЭЭ

№	Гүйцэтгэх ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Төсөвт өртөг,төг	
				Нэгжийн	Бүгд
I.Хээрийн ажил -Өрөмдлөг, шавхалтын ажил					
1	Цооног өрөмдлөг (219 mm)	т.м	100	165,000.0	16,500,000.00
2	Турба дулийн (219 mm)	т.м	18	135,000.0	2,430,000.00
3	Кемпийн худгийн тоноглол (PVC 125 mm)	т.м	100	18,000.0	1,800,000.00
4	Шавхалт туршилтын ажил	цаг	48	70,000.0	3,360,000.00
Дүн					24,090,000.00
ДҮН					24,090,000.00
НӨАТ 10%					2,409,000.00
НИЙТ ДҮН					26,499,000.00

Тайлбар: 1. Орон нутгийн болон холбогдох бусад зөвшөөрлийг захиалагч бүрэн харууцана.

2. Насос болон холбох хэрэгсэл ОРСОН болно.

Гүйцэтгэх захирал



Ч Намдорж

Хавсралт 5. Ордын гидрогеологийн судалгааны ажлын гэрээ



Нэг талаас: "Хандгайтгол" ХХК /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлж Х.Лхагвасүрэн
Нөгөө талаас: "Сойл Инжинеринг" ХХК /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж
Гүйцэтгэх захирал менежер Ч.Нямдорж нар Монгол улсын Иргэний хуулийн 343-358-р зүйлийг
үндэслэн дараах нөхцөл бүхий гэрээг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний Хавсралт 1 -т тохиролцсон Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Хандгайт гол уурхайн ордын гидрогеологийн судалгаа, өрөмдлөг, шавхалт туршилтын ажил, лабораторийн туршилт, тайлан дүгнэлт боловсруулах ажил /300 тууш метр/ /цаашид "Гэрээт ажил" гэх/-ыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, Захиалагчийн шаардлагад нийцүүлэн, чанарын өндөр түвшинд гүйцэтгэн Захиалагчийн өмчлөлд хүлээлгэж өгөх, Захиалагч нь Гүйцэтгэгчийн доголдолгүй гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч энэхүү гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлон зохицуулахад оршино.
- 1.2 Гүйцэтгэгч нь инженер-геологийн судалгааны ажлын хүрээнд Захиалагчийн даалгавраар заасан талбайд өрөмдлөг хийж тоноглол, цооногт шүүрэлт тодорхойлох, өрөмдлөгийн ажлын тайлан бичиж баримтжуулахад хийнэ.
- 1.3 Энэхүү гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль түүнд нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁР. Гэрээний зүйл

- 2.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь гэрээний 1.1 дэх хэсэгт тодорхойлсон барилгажих талбайд Хавсралт №1-т заасан өрөмдлөг тоноглол, цооногт шүүрэлт тодорхойлох ажлыг Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, Захиалагчийн шаардлагад нийцүүлэн, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэж өгнө.

ГУРАВ. Гэрээний хугацаа

- 3.1 Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг 2024 оны 06-р сарын 03-ны өдрөөс эхлэн 60 хоногийн хугацаанд гүйцэтгэж Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
- 3.2 Захиалагчтай холбоотой бусад шалтгаанаар хойшлогдсон хугацааг энэ гэрээний 3.1-р зүйлд заасан ерөнхий хугацаан дээр нэмж тооцно.

ДӨРӨВ. Гэрээний үнэ, төлбөр төлөх журам

- 4.1 Гэрээний нийт үнийн дүн нь /НӨАТ/ орсон дүнгээр 83,707,030 /Наян гурван сая долоон зуун долоон мянга гучин / төгрөг болно.
- 4.2 Энэхүү гэрээний нийт үнийн дүнд Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 100 тууш метр өрөмдлөгийн үнэ, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний цалин хөлс, томилалт, компанийн ашиг, аливаа татвар хураамж зэрэг бүхий л зардлууд орсон болно.
- 4.3 Захиалагч нь гэрээний төлбөрийг дараах журмаар төлнө. Үүнд:
 - 4.3.1 Гэрээ байгуулагдаж хүчин төгөлдөр болсоноор нийт үнийн дүнгийн 10%-тай тэнцэх төлбөр буюу 8,370,000.00 төгрөгийг
 - 4.3.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөр үлдэгдэл 90%-тай тэнцэх төлбөрийг Захиалагч 2024 оны 10-р сарын 15-ны дотор 75,337,090.00 төгрөгийг Гүйцэтгэгчийн

харилцах дансанд шилжүүлнэ.

**ТАВ. Гүйцэтгэх ажлын үр дүн, тавигдах шаардлага,
хүлээлэгн өгөх журам**

- 5.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох стандарт, Захиалагчийн хүсэл сонирхол, тавьсан шаардлагын дагуу мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 5.2 Гүйцэтгэгчийн энэхүү гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг Захиалагч шалгах бөгөөд ажлын үр дүн холбогдох стандарт, Захиалагчаас тавьсан шаардлагад нийцсэн гэж үзвэл ажлын үр дүнг баталгаажуулан актаар хүлээн авна.
- 5.3 Хэрэв гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэсэн, эсвэл зураг төсөл, өгсөн даалгавраас зөрүүтэй гүйцэтгэсэн нь шалгах явцад илэрсэн бол Гүйцэтгэгч доголдлыг Захиалагчаас тогтоосон хугацаанд үнэ төлбөргүй арилгах ба ийнхүү арилгах хүртэл Захиалагч гэрээт ажлын үр дүнг хүлээн авахгүй.
- 5.4 Өрөмдлөгийн ажлын тайлан дүгнэлтийг Монгол, Англи хэл дээр хоёр хувь хийж, Захиалагчид актаар хүлээлэгн өгнө.

ЗУРГАА. Захиалагчийн эрх, үүрэг

- 6.1 Өрөмдлөг явуулах объектын тогтоосон масштабтай дэвсгэр болон байрзүйн зургийг гаргаж өгөх буюу байршлыг газар дээр нь зааж өгнө.
- 6.2 Судалгааны талбайд цахилгаан, холбоо, цэвэр ба бохир усны инженерийн байгууламжийн шугамыг оруулахгүй байлгах нөхцлийг хангасан байна. Үүнээс үүссэн аливаа асуудлыг өөрөө хариуцна.
- 6.3 Гүйцэтгэгчийн гэрээт ажлын гүйцэтгэлд байнга хяналт тавьж, мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 6.4 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг Захиалагчийн эрх бүхий төлөөлөгч нарийн шалгаж актаар хүлээн авах бөгөөд ийнхүү шалгах явцад ажлын үр дүн, тайланд аливаа доголдол илэрсэн, өгсөн зөвлөмжийг дагаагүй нь тогтоогдвол Гүйцэтгэгч доголдлыг шаардлагад нийцүүлэн арилгах хүртэл Захиалагч хүлээн авахаас татгалзах ба Гүйцэтгэгчээр доголдлыг үнэ төлбөргүй арилгуулах, гуравдагч этгээдээр доголдлыг арилгуулсан тохиолдолд холбогдон гарсан зардлыг төлүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд Гүйцэтгэгчийн доголдол арилгасан хугацааг гэрээний хугацааг хэтэрсэнд тооцно.
- 6.5 Гүйцэтгэгчээс хүлээлэгн өгч байгаа гэрээт ажлын үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй.
- 6.6 Гэрээний төлбөрийг гэрээгээр тохирсон журмын дагуу хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- 6.7 Аливаа газрын маргаантай асуудал тулгарвал нэн даруй шийдвэрлэх ба өрөмдлөг явуулах хэвийн нөхцөлийг хангах, эс чадвал сул зогсолтыг хойшлогдсон хоног тутам төлөх үүрэгтэй.
- 6.8 Цооногт шүүрэлт тодорхойлоход ашиглах усан хангамжийг өрөмдлөгийн талбайд бэлэн байлгах

ДОЛОО. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 7.1 Захиалагчийн завсан газарт энэхүү гэрээний 2.1 дэх хэсэгт өрөмдлөг хийж тоноглол, шүүрэлт тодорхойлох, тайлан, зураг зүсэлт боловсруулах ажлуудыг мэргэжлийн түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 7.2 Захиалагчаас гэрээгээр тохиролцсон төлбөрийг хугацаанд нь хийхийг шаардах эрхтэй.
- 7.3 Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам зааврыг чанд мөрдөж ажиллах бөгөөд үйдвэрлэлийн осол гаргахгүй байхаас гадна гуравдагч этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлж ажиллана. Үүнтэй холбогдуулан үүссэн аливаа хохирлыг өөрөө хариуцна. Ажлын талбайд ажиллах ажилчдаа хөдөлмөрийн сахилга баттай, нарийн зохион байгуулалттай ажиллуулж, аливаа зөрчил дутагдал гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах ба зөрчил дутагдал гаргасан бол үүссэн хохирлыг Гүйцэтгэгч өөрөө бүрэн хариуцна.
- 7.4 Гүйцэтгэгчийн ажилчид гэрээт ажлыг гүйцэтгэх явцад, гэрээ дуусгавар болсоны дараа Захиалагчийн талаарх аливаа мэдээллийг нууцлан хадгалах ба бусдад мэдээлэхгүй. Энэ үүргээ зорчсонтэй холбогдон үүссэн хохирлыг Захиалагчид бүрэн нөхөн төлнө.
- 7.5 Захиалагчаас Гүйцэтгэгчид шилжүүлсэн баримт бичиг, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд ажил гүйцэтгэж дууссаны дараа Захиалагчид эргүүлэн шилжүүлэх үүрэгтэй.

- 7.6 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Захиалагчийн хөдөлмөрийн дотоод дүрэм, журмыг мөрдөж ажиллана.
- 7.7 Захиалагчийн аливаа гуравдагч этгээдийн нэхэмжлэл, маргаан, төлбөр зэргээс ангид байлгах үүрэгтэй.

НАЙМ. Хариуцлага

- 8.1 Гүйцэтгэгч гэрээт ажлыг хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 8.2 Захиалагч нь гэрээний үнийг харилцан тохиролцсон журмын дагуу шилжүүлээгүй тохиолдолд төлбөрийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0,5%-тай тэнцэх алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

ЕС. Гэрээ цуцлах

- 9.1 Гэрээг дараахь тохиолдолд Захиалагч дангаар цуцална.
- 9.1.1 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлаа хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй 15 (арван тав) хоног өнгөрсөн.
- 9.1.2 Гүйцэтгэгч нь дампуурсан эсвэл бусдад эрхээ шилжүүлсэн.
- 9.1.3 Гүйцэтгэгч нь хариуцсан ажлаа удаа дараалан (2 ба түүнээс дээш) чанаргүй гүйцэтгэсэн.
- 9.1.4 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу үүрэг хүлээх чадваргүй нь нэгэнт тогтоогдсон.
- 9.2 Торгууль алданги төлсөн нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхээс чөлөөлөхгүй.
- 9.3 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй 15 ба түүнээс дээш хоног хэтэрвэл Гүйцэтгэгч өөрийн санаачлагаар гэрээг цуцална. Үүнээс үүссэн бодит хохирлыг Захиалагч тал хугацаа хэтэрсэн хоног тутамд тооцсон алдангийн хамт төлнө.

АРАВ. Бусад нөхцөл

- 10.1 Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгийн хэлбэрээр үйлдэгдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2 Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэнэ. Маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 10.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдвол талууд энэ талаар бичгээр нөгөө талдаа ажлын нэг хоногийн дотор мэдэгдэж зөвшилцөж шийдвэрлэнэ. Давагдашгүй хүчин зүйл учирсныг зөвхөн эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэж тогтооно.
- 10.4 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэн, талууд тус бүр хоёр хувийг хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Нэмэхбаяр, Уурхайн ерөнхий инженер
Утас: 88073007
СЭЛЭНГЭ АЙМАГ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Ч.Нямдорж, Гүйцэтгэх захирал
Утас: 88107265

малчны худаг болон ордын гидрогеологийн судалгааны гэрээний үнийн дүн болон телберийн хувиарь

№	хийгдэх ажлууд	талбайн байршил	ажлын тоо	ажлын хэмжээ Т.М	үнийн дүн, телберийн хувиар				тайлбар
					Урьдчилгаа	явцын телбер	үлдэгдэл телбер	нийт телбер	
1	Малчны гүний худаг	Ерөө сум, сумын засаг даргаас өгсөн 2 цэгт	2 ширхэг	100	8,000,000.00	8,000,000.00	10,499,000.00	26,499,000.00	насос, кабель, тросс телбер нэмэгдэх
2	Ордын гидрогеологийн судалгаа	Ерөө сум, Хандгайт гол уурхай	2 ширхэг	300	8,370,000.00		75,337,030.00	83,707,030.00	шавхалт туршилт, хяналтын цооногын зориулалтаар тоноглох, тайлан, дүгнэлт, жил бүрээр шүүрлийн усны тооцоо

Өрөмдлөг, худаг ус, судалгааны
СОЙЛ ИНЖИНЕРИНГ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, М Плаза Центр, 10-р давхар
 Утас: 70135666, Факс: 976-11-70135666. Мобил: 9911-5666, 9907-7661

2024 оны 03-р сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ ТӨМӨРИЙН ХҮДРИЙН ОРДЫН ТАЛБАЙН
 ГИДРОГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ҮНЭЛГЭЭ

№	Гүйцэтгэх ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Төсөвт өртөг, төг	
				Нэгжийн	Бүгд
1.Хээрийн ажил -Өрөмдлөг, шавхалтын ажил					
1	Оррдын гидрогеологийн өрөмдлөг (219 мм)	т.м	300	168,000.0	50,400,000.00
2	Цооног тоноглох PVC (125 мм)	т.м	300	18,000.0	5,400,000.00
3	Цэвэрлэгээ хайргаар тоноглох /5-10мм/	тн	3	180,000.0	540,000.00
4	Шавхалт туршилтын ажил	цаг	48	70,000.0	3,360,000.00
Дүн					59,700,000.00
2.Суурин боловсруулалт -Лабораторийн туршилт					
1	Бүрэн химийн шинжилгээ	сорьц	3	60,000.0	180,000.00
2	Бичил элемент тодорхойлох	сорьц	3	105,000.0	315,000.00
3	Нян шинжилгээ	сорьц	1	95,000.0	95,000.00
4	Тайлан дүгнэлт боловсруулах	Хээр	15%	59,700,000.0	8,955,000.00
Дүн					9,545,000.00
3.Тээвэрлэлт					
1	Тээврийн зардал / 1 өрөм, 1 компрессор, 1 ачааны машин, 1 дагавар тэрэг /				6,852,300.00
Дүн					6,852,300.00
ДҮН					76,097,300.00
НӨАТ 10%					7,609,730.00
НИЙТ ДҮН					83,707,030.00

Тайлбар: 1.Орон нутгийн болон холбогдох бусад зөвшөөрлийг захиалагч бүрэн хариуцана.

2.Ашиглалтын Хүдгийн тоноглол хийх цахилгаан үүсгүүр, насос, кабель, насосны дагалдах хэрэгсэл, үс өргөх яндан хоолой орсон.

Гүйцэтгэх захирал



Ч.Нямдорж

Хавсралт 6. Уурхайн хуулсан шимт хөрстэй ажиллах журам



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
 оны... сарын ...өдрийн ...тоот
 тушаалын...хавсралт

Баримт бичгийн төрөл, дугаар	Журам
Үйлчлэх хүрээ	Энгис ХХК, түүний хараат болон охин, зэргэлдээх компани, гэрээт компаниуд
Хариуцах нэгж	ЭМААБО хэлтэс
Нууцын зэрэглэл	Нууц бичиг
Танилцсан	Бүх хэлтэс болон гэрээтүүдэд

УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

Багалгаажуулалт

	Нэр албан тушаал	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан:	Батчимэг Батсайхан Байгаль орчны мэргэжилтэн		2022.06.09
Хянасан:	Нэмэхбаяр Ганбат Ерөнхий инженер		2022.06.09
Батацсан:	Лхагвасүрэн Хандаа Гүйцэтгэх захирал		2022.06.09



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
Оны... сарын ...өдрийн ...тоот
тушаалын...хавсралт

УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энгис ХХК -ийн уурхайн шимт хөрстэй ажиллах харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журам нь "Энгис ХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани, туслах гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд хамааран уйлчилнэ.

УУРХАЙН ХУУЛСАН ШИМТ ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

1.3.Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг холбогдох дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу шийдвэрлэнэ.

1.4 Шимт хөрсийг хуулах үйл ажиллагаанд MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томъёо, тодорхойлолт, MNS 5915:008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал, MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2008 Эвдэрсэн газрын ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага, Шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас зэрэг холбогдох стандарт, хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Шимт хөрс, түүнтэй ажиллах

2.1. Уурхайлалт гэдэгт олборлох, хөрс хуулах, тээвэрлэх, барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэд бүтцийг байгуулах бүх үйл ажиллагааг хамруулан ойлгох бөгөөд шимт хөрсийг байгаль орчныг нөхөн сэргээх зориулалтаар дахин ашиглана.

2.2 Шимт хөрс гэдэг нь ургамал ургахад шаардагдах үржил шим, агрохими, механик бүрдэл бүхий нөхцлийг хангасан буюу энгийн сайжруулалт хийх боломжтой хөрсний өнгөн хэсэг бөгөөд энэ хэсгийг дахин боловсруулна.

2.3 Шимэрхэг хөрс гэдэг нь ургамлын ургалт, төлжилтөнд хязгаарлагдмал хүрээнд таатай нөлөө үзүүлэхүйц физик, хими шинж чанар бүхий уулын чулуулаг болно.

2.4 Хөрсний урьдчилсан үнэлгээ гэдэг нь үйл ажиллагаа явуулах талбайн шимт хөрсийг хуулахаас өмнө хөрсний чанарыг магадлан нөөцийг хэсэгчилэн тогтоох ажиллагаа бөгөөд уг үнэлгээгээр шимт болон шимэрхэг хөрс хуулах зузааныг тогтооно.

2.5 Шимт хөрс хуулалт нь нөхөн сэргээлтэд зориулан хөрсний бүрэлдэхүүн хэсгийг хадгалах зорилгоор хөрсний үржил шимт давхаргыг урьдчилсан үнэлгээнд заасан гүн хүртэл хуулах үйл ажиллагааг бөгөөд хэрэв үнэлгээ хийгдээгүй бол хуулах зузааныг уулын ажлын төлөвлөгөөнд заасан хэмжээгээр тооцож, авна.

2.6.Нөхөн сэргээлтэнд ашиглах зорилгоор хуулсан шимт хөрсийг заасан овоолго буюу агуулах талбайд хадгалах, шимт чанар, нөөцийг алдагдуулахгүйгээр хамгаалах арга хэмжээ авна.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
оны... сарын ...өдрийн ...тоот
тушаалын...хавсралт

2.7. Бороо, цас, ус, мөс, салхи, температурын өөрчлөлт, татах хүч зэрэг физик, химийн хүчин зүйлийн нөлөөгөөр эсхүл хөрс болон геологийн зүйлийг газрын гадаргын нэг цэгээс өөр нэг цэг рүү хөрсийг хамаах, салгах буюу зайлуулах байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас газрын гадаргуу элэгдсэнд нөхөн сэргээлт хийнэ.

2.8. Шимт хөрсний овоолгын өндрийн хязгаар, эцсийн хэлбэрийн дээд болон хажуугийн налуу, шимт хөрс хуулах зузаан зэрэг уулын ажлын тоон үзүүлэлтийг шимт хөрсний параметр гэх бөгөөд тухайн жилд батлагдсан Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу уг ажлыг гүйцэтгэнэ

2.9. Элэгдсэн газрын үржил шимийг сэргээх, хүрээлэн байгаа орчны нөхцөлийг сайжруулахад чиглүүлж, нөхөн сэргээх зарга хэмжээг авна.

Гурав. Шимт хөрс хуулах, төлөвлөх, бэлтгэл ажил

3.1. Тухайн жилд уурхайн ахилтанд өртөж хуулагдах талбай, шимт хөрсний хэмжээ болон овоолго үүсгэн байрлуулах талбайн байршил, хэмжээг "Энгис" ХХК-ийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгана.

3.2. Уг төлөвлөгөөнд тухайн жилд олборлох шимэрхэг хөрсний хэмжээ болон байршуулах овоолгыг мөн адил төлөвлөнө.

3.3 Шимт хөрс хуулахаас өмнө талбайд цэвэр усны эх үүсвэр хөндөгдөх, ховордсон өвс, ургамал өртөх эсэхийг тогтоон шаардлагатай бол нөхөн сэргээлтийн талбайд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.4 Уурхайн ахилтанд өртөх талбайд Энгис ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээг хийж, шимт хөрс хуулах зузааны хэмжээг тогтооно. Говийн бүсэд шимт хөрсийг 0-40 см хүртэл гүн хуулахаар тогтооно. Шимт хөрст талбайд хөрсний тодорхой гүнүүдээс дээж авч шинжлүүлэн хөрсний үржил шим, механик бүрдлийг тодорхойлон шаардлагатай бол чанарын хэсэгчилсэн зураг гарган боловсруулж батлуулна.


Дөрөв. Шимт хөрс хуулах, зөвшөөрөл олгох

4.1 Энгис ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээ, уулын ажлын төлөвлөгөө, болон бусад төлөвлөлтийг үндэслэн шинээр газар хандах хөрс хуулах тохиолдол бүрт шимт хөрс хуулах зөвшөөрөл олгоно.

4.2 Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөндөгдөх талбайн хил хязгаар, өндрийн түвшинг уурхайн маркшейдэр инженер гадаслаж тэмдэглэнэ.

4.3. Хөрс хуулах явцад шимт хөрсний гүнд чанар муутай хөрсний материал орохоос ямагт сэргийлэх хэрэгтэй.

4.4. Хөрс хуулалтад өөрчлөлт гарах болсон тохиолдолд "Энгис" ХХК-ийн Байгаль орчны болон ашиглалтын инженерт ерөнхий мэдэгдэн мэргэжилтэн тухайн тушаалтнуудын шийдвэрээр хуулах гунийг өөрчилж болно.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
оны... сарын ...өдрийн ...тоот
тушаалын...хавсралт

4.5 Шимт хөрсийг хуулалт байрзүйн хувьд өндрөөс нам руу чиглэн явагдана.

4.6.Шимт хөрс хуулсан хэсэгт маркшейдерийн хэмжилт хийлгэж, хөндөгдсөн талбайн болон эзэлхүүний хэмжээг долоо хоногийн тайланд, хадгалах талбайд буусан шимт хөрсний хэмжээг сарын тайланд тус тус тусгана.

4.7.Хэрэв маркшейдерийн хэмжилтээр шимт хөрс хуулах гүнд хүрээгүй эсвэл хуулсан хөрсний эзэлхүүн дутуу байгаа тохиолдолд шимт хөрсийг дахин хуулуулж заасан хэмжээнд хүргэнэ.

4.8.Салхины хурд ихтэй, хэт их хуурайшилт ихтэй үед шимт хөрсийг аль болох хуулахгүй, тээвэрлэхгүй байхыг эрмэлзэх бөгөөд зайлшгүй хуулах, зөөх тохиолдолд шимт хөрсийг салхинд зөөгдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.9.Шимт хөрсийг өдрийн цагаар хуулна. Зайлшгүй шөнийн цагаар хуулах шаардлагатай нөхцлийг уурхайн төлөвлөлтийн инженер батласан тохиолдолд шимт хөрс хуулах ажил бүрт байгаль орчны мэргэжилтэн шене шимт хөрс хуулах зөвшөөрлийг олгоно.

4.10.Түр хугацаагаар байгуулах зам, усны хоолой зэрэгт шимт хөрсийг заавал овоолгод байршуулахгүйгээр салхины хаалт маягаар овоолж эргүүлэн ашиглаж болно.

4.11 Уурхайн ахилт болон тэлэлт хийхдээ шимт хөрсийг хугацаанаас нь эрт хуулахгүй байх. Хуулсан даруйд нөхөн сэргээлтэнд ашиглахыг чухалчилна.

Тав. Шимт хөрсийг хадгалах

5.1. Шимт хөрсийг зөвхөн нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглана.

5.2 Шимт хөрсний овоолгын зөвшөөрөгдөх хамгийн дээд өндөр нь 5 метр байна.

5.3.Овоолгыг хэлбэршүүлэхдээ хотгор гадаргуугийн талбайг багасгахын тулд шимт хөрсний овоолгын хажуугийн налууг 15 градус, дээд гадаргын налууг 5 градусаас ихгүйгээр тэгшилнэ.

5.4.Гурван жилээс дээш хугацаанд хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу хажууг хэлбэржүүлж олон наст өвслөг ургамал тарина.


5.5.Шимт хөрсний хадгалалт, тордлогын бүртгэлийн тайланг жилд 2-оос доошгүй удаа хийнэ.

5.6.Шимт хөрсийг хуулсан даруйд төлөвлөгдсөн талбайруу зөөж хадгална.

5.7 Шимт хөрсийг овоолсон цагаас эхлүүлдээ нөхөн сэргээлтэнд ашиглах хүртэл жил бүр чанарын болоод бохирдлын шинжилгээнд хамруулж, шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлэх ба газрын зураг дээр байршлийг нь тэмдэглэж мэдээллийн санд хадгална.

Зургаа. Үүрэг хариуцлага

6.1.Албан тушаалтан дор дурьдсан үүрэг, хариуцлага хүлээнэ.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
оны... сарын ...өдрийн ...тоот
тушаалын...хавсралт

6.1.1.ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн шимт хөрсийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих.

6.1.2."Энгис" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн энэ журмын хэрэгжилтийг дүгнэх, шимт хөрс хамгаалах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, шимт хөрс хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмж, тарих үрийн судалгааг хийж, захиалж бэлэн байлгах,

6.1.3. Энгис" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь уг журмын хэрэгжилтэнд хяналт хийж зөрчлийг мэдээлэх, арилгах, шимт хөрсний хуулалт, овоолгын байдал, нөөц болон чанарын хяналт явуулах, шимт хөрстэй холбоотой мэдээллийн санг үүсгэж хариуцах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.4.Төлөвлөлтийн инженер нь тухайн жилийн уулын ажлын төлөвлөлтөнд шимт хөрсний хэмжээ, шимт хөрсний овоолго үүсгэх талбай, хуулалт хийгдэх хуваарийг гаргах, шимт хөрсний байршлын зураг боловсруулах, техникийн паспорт үйлддэг байх;

6.1.5.Уулын мастер нь шимт хөрс хуулах, овоолго үүсгэх, хэлбэржүүлэлт хийх ажилд хяналт тавих;

6.1.6. Уулын гэрээг ажил гүйдэтгэгчийн байгаль орчин хариуцсан ажилтан нь шимт хөрсний хуулалт, овоолгын байдал, нөөц болон чанарт байнгын хяналт явуулах, шимт хөрс хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулан, зохион байгуулах;

6.1.7.Шимт хөрсний чанарыг доройтуулах үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлтээс өөр зориулалтаар ашиглах, шимт хөрс хуулах зөвшөөрөлгүйгээр хуулалт хийхэд хяналт тавих;

6.2.Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, "Энгис" ХХК-ий Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгтээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

Долоо. Бусад

7.1.Шимт хөрсний хадгалалт, хамгаалалтад бүртгэл, хяналт хийх зорилгоор дор дурдсан мэдээллийг тогтмол шинэчлэн мэдээллийн санд хадгална.

7.1.1.Шимт хөрсний овоолгын төлөвлөлт: (уулын ажлын төлөвлөгөөнд туссанаар)

7.1.2. Шимт хөрс хуулах, овоолго хийх хуваарь.

7.1.3.Шимт хөрс хуулсан талбайн хэмжээ, овоолгын байршлын зураг (ArcGIS).

7.1.4. Шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас.

7.1.5.Хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан.

7.1.6.Газарзүй мэдээллийн системд байрзүйн болон чанарын хэмжилтийн мэдээллийг 6 сарын давтамжтайгаар оруулж орон зай, цаг хугацааны мэдээг үүсгэнэ.

7.1.7 Шимт хөрс хадгалах байгаль орчны төлөвлөгөө зэрэг болно.



Энгис ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2022
 оны... сарын ...өдрийн ...тоот
 тушаалын...хавсралт

Найм. Хавсралтууд
 Хавсралт-1. Шимт хөрс хуулах зөвшөөрөл.

❖ Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:	Хүсэлт гаргасан хэлтэс/ Гэрээт компани:		
Хүсэлт гаргасан ажилтны овог нэр:			
тас:	Албан тушаал:		
Шимт хөрс хуулах байрлал:	Уурхай <input type="checkbox"/>	Хотхон <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>
